

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2019 оны 1 сарын мэдээ/

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	8881	11363	6385	3607	539	30775
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	2142	3063	698	229	434	6566
3	Идэвхтэй хяналтын үзлэг	1194	2031	1655	307		5187
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	2941	2954	1892	910	92	8789
5	Нийт төрөлт	88	25				113
6	Хэвтэн эмчлүүлэгчид	753	559		150	8	1470
7	Нас баралт	2	22	8			32

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 30775 хүнд үзлэг шинжилгээ хийсний 38,2%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 1470 хүнийг 9719 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.6 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 1 сарын байдлаар 8789 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2739 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 1 сарын байдлаар 81 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 4 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 29 тохиолдлоор буурч, осол гэмтлийн нас баралт 1-р өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын 75% /3/ нь амиа хорлож, 45%/1/ нь ахуйн ослоор тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсад нь бүгд 29-44 насны эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 75% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 1 хүн нь хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. /сумдаар нь гаргах/
5. Оны гарсаар 32 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 12,5% нь осол гэмтлээр /Гт-2,Хх,Хб/,37,5% хорт хавдраар,12,5% зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 3,1% /Хб/нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
6. Нялхсын эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 1 тохиолдлоор өссөн ба 1000 амьд төрөлтөд 8,9 байна.

7. Түргэн тусламжийн 1799 дуудлагад явж үйлчилсний 256/14.2%/ нь алсын дуудлага, 35/2%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 94.2% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
8. 1 сард 3992 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 48,1% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 7 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,1%-г эзэлж байна.
9. Нийт 113 эх төрж 112 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 9 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1:1,1 байгаа ба эмэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 7% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна/**сумдаар нь гаргах**/ .
10. 1 сарын байдлаар 44 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 392,8 байгаа нь өнгөрсөн оноос 1,5% буурсан үзүүлэлт байна.
11. Он гараад 39 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 8 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 51,2%-г салхинцэцэг, 5,1%-г гар хөл амны өвчин, 30,7%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
12. ЭЭСангуудад нийт 1920 жор ирсний 48,6%/933/ нь ЭМДаатгалын, 0,1% /3/ мансууруулах эмийн, 2% /40/ сэтгэц нөлөөт эмийн, 49,1% /944/ нь энгийн эмийн жор байсан ба 0,4% /8/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 84,2% байна.
13. БОЭТөвд 2 эндэгдэл тохиолдож 1 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 100% тай байна. Үндсэн оношийн зөрөө 0%.

Мэдээлэл бэлтгэсэн: ЭМГ-н статистикч Б Мидэрсүрэн , Д. Гантогтох